

2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИТХ-д
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ **МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Би:

- Монгол улсын хууль цааз, төрт ёсны уламжлал, хүн байгалийн гайхамшигт харилцан шүтэлцээ, зан заншил, монгол хүний ёс жудаг, өвөг дээдсийн сургаал номлол, захиас даалгавар, эдүгээ хүртэл баримталж ирсэн бодлогыг дээдэлнэ.
- Орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд тулгарч буй бэрхшээл, саад тогторыг гэтлэн давах, арга замыг тодорхойлох, төр засагтаа итгэх алдарч цөхөрсөн ард түмнээ хямралаас гаргахыг, алдаа оноог нь дэнслэн, шинэ хөгжлийн бодлогыг дэвшүүлэхийг эрхэм зорилгоо болгон мөрийн хөтөлбөрөө толилуулж байна.

Би:


Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжиж ажиллана

Монгол улсын Боловсролын Хөгжлийн Бодлогын шинэчлэлийн хөтөлбөрт үндэслэн орон нутгийн боловсролын салбар нь бие дааж, өөрөө хөгжих чадвартай эрдэм боловсролтой, эрүүл чийрэг иргэнтэй болох зорилгод нийцсэн боловсролын тогтвортой хөгжлийн бодлого боловсруулна.

Бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг орон нутгийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, иргэдийг оролцуулан тэдний санал санаачлагад тулгуурлана.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтод хяналт тавих хараат бус, хөндлөнгийн шинэ механизмыг бий болгоно.

Өвөг дээдсийн арвин их сургаал номлол, улс эх орныхоо тогтвортой хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалд тулгуурлан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.



Уриа: Боловсролыг дээдлэж, хөгжлийг эрхэмлэнэ.

Мерийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ:

1. Орон нутгийн бие даасан хөгжлийн бодлогыг боловсронгуй болгоно.
2. Орхон аймгийн иргэн гэдгээрээ бахархдаг өндөр боловсролтой, эрүүл зөв харилцаатай иргэн байх ёс зүйн дүрэм боловсруулна.
3. Зорилтот бүлэг, ахмад, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.
4. Бүтээлч сэтгэлгээтэй иргэдийн оюун санаа, ур чадвар, бизнесийн үйл ажиллагааг орон нутгийн хөгжилд татан оролцуулах бодлого боловсруулна.
5. Сөрөг хүчний зөв үйл ажиллагааг дэмжиж төрийн үйл ажиллагааг улс төрөөс ангид байх зарчмыг баримтлана. “Экологийн цэвэр- Ногоон хот” болох зорилтыг дэмжин Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх “Эко” сургалтын хөтөлбөр боловсруулна.
6. Удирдах ажилтнуудын манлайллын шалгуур үзүүлэлтийг тогтоож энэхүү шалгуурыг хангасан хүнийг төрийн удирдах албанд ажиллуулах шаардлага тавих ба улс төрөөс ангид байх зарчмыг баримтална.
7. Аймгийн онцлог, нөөц боломжинд тулгуурлан бүс нутгийн бодлого төлөвлөлт, уулын үйлдвэртэй уялдуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг иргэд олон нийтийн оролцоонд чиглүүлнэ.
8. Өрхийн болон жижиг үйлдвэрлэл эрхлэгчдэд ур чадвар эзэмшүүлэх, төсөл хөтөлбөр боловсруулан, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээгээр хангах сургалтын төвүүдийг багуудыг түшиглэж байгуулна.
9. Хөдөлмөрийн насны Иргэн бүрт хөдөлмөр эрхлэх боломжийг олгож, жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, хоршооллыг дэмжинэ.
10. Орхон аймгийн амьжиргааны өртөгтэй уялдуулан үйлдвэрийн цалин дагасан бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтвортой байлгах хяналтын тогтолцоог сайжруулна.
11. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар хүртээмжийг сайжруулах тогтолцооны хөтөлбөрийг боловсруулж аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулна.
12. Иргэдийн ая тухтай, амгалан тайван, эрүүл аюулгүй амьдрах нөхцлийг хангах
13. Сургууль цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх, сургуулийн бүтэц, сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
14. Чадварлаг багш, авъяаслаг, гоц авьяастай хүүхдүүдийн чадвар, ур дүнг урамшуулан дэмжих бодлогыг орон нутгийн өөрөө удирдах байгууллагад асуудал болгон дэвшүүлэн тавьж шийдүүлэх чиглэлийг баримтална.
15. Орхон аймгийн инженерийн шугам сүлжээг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, нийтийн тээвэр, эрчим хүчний хэмнэлттэй ухаалаг төхөөрөмжүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн тасралтгүй байдлыг дэмжинэ.
16. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөтэй утаа, хөрс, усны, цагаан тоосны бохирдлоос болж эрүүл мэндээр хохирсон иргэний оношлогоо, үзлэгийн асуудлыг шат дараалан бүрдүүлнэ.

